

Арван хууль

1.Надаас өөр Бурхадтай байж болохгүй. 2. Өөртөө зориулж шүтээн бүү хий. 3. Өөрийн Бурхан Эзэний нэрийг дэмий бүү дурьд. 4. Амралтын өдрийг ариунаар сахь. 5. Эцэг эхээ хүндэл. 6.Хүн бүү ал. 7.Бүү завхайр. 8. Бүү хулгайл. 9. Худал бүү гэрчил. 10. Бүү шунахайр. Чи шүүлтийн өдөр Бурхантай уулзана. Тэр, тачаадан харахыг завхайрсанд тооцдог. “Эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй аль хэдийн завхайрсан хэрэг” (Матай 5:28) Тэр үзэн ядагчыг алуурчин гэж үздэг. “Ахан дүүгээ үзэн яддаг нэгэн нь алуурчин мөн” (1 Иохан 3:15) Та диваажинд очих уу? Үүнийг хурдан шалгаж болно. Та ер нь худал ярьдаг уу, хулгай хийсэн үү, Бурханы нэрийг дэмий дуудсан уу аль эсвэл тачаадан харсан уу? (Иаков 2:10) “Учир нь бүх хуулийг сахивч нэг дээр нь бүдрэх хэн боловч бүх хуулийг зөрчсөн болно.” Шүүлтийн өдөр болоход та гэмтэйгээ байх уу? Хэрэв Бурхан чиний худал ярьж, хулгай хийж, харааж, зүрхэндээ завхайрсныг чинь харсан бол. Библи биднийг гэмтэйгээ байвал тамд очихыг сануулдаг. Бурхан өөрийн хүүг загалмайн зовлонгийн төлөө өгсөн. Есүс өөртөө бүх шийтгэлийг авсан. “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц хүүгээ өгсөн. Ингэснээр хүүд итгэгч хэн ч мөхөхгүй харин Мөнх амьтай болно. (Иохан 3:16) Тэгээд Есүс үхлээс дахин амилж үхлийг ялан дийлсэн. Өнөөдөр гэмш гэмээсээ эргэ Есүст итгэ, Бурхан та нарт мөнх амь өгнө. Библи уншиж, уншсанаа дуулгавартайгаар биелүүл.

Бурханы үг 1

Та аврагдах хэрэгтэй. “Үнэнээр би чамд хэлье. Хэн дээрээс эс төрнө, тэр Бурханы хаанчлалыг үзэхгүй”. (Иохан 3:3) Бид бүгдээрээ хонь мэт төөрч, хүн бүр өөрсдийн замаар явав. (Исаиа53:6) ЭЗЭН Би зүрхийг эрэлхийлж оюун бодлыг шалгадаг нь хүн бүрд замуудынх нь дагуу, үйлсийнх нь үр дүнгийн дагуу өгөхийн тулд юм.(Иеремиа 17:10) Хэрэв та нар гэмшихгүй, Бурхан руу эргэхгүй бол бүгд мөхнө.(Лук 13:3) Хэн ч өөрийгөө аварч чадахгүй. Тэр биднийг зөвт байдлын доторхи үйлсээр минь бус, харин Өөрийнхөө өршөөлийн дагуу шинэтгэлийн угаал ба Ариун сүнсний сэргээлтээр аварсан юм. (Тит 3:5) Хүнд зөв мэт санагдавч төгсгөл нь үхэл рүү хөтөлдөг зам байдаг. (Сургаалт үгс 14:12) Есүс: Би бол зам үнэн амь мөн. Хэн ч надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй.(Иохан 14:6) Яагаад гэвэл ямар ч махан бие хуулийн үйлсээр Түүний өмнө зөвтгөгдөхгүй. Хуулиар нүглийн мэдлэг ирдэг юм.(Ром 3:20) Биднийг нүгэлд үхүүлж, зөвт байдалд амьдруулахын тулд Тэр өөрөө бидний нүглийг модон дээр биедээ үүрсэн. Та нар түүний шархаар эдгэрсэн билээ.(1 Петр 2:24) Христ бидний нүглийн төлөө үхээд гурав дахь өдөртөө дахин амилуулагджээ.(1 Коринт 15:3-4) Та нар итгэсэн тул нигүүлсээр аврагджээ. Энэ нь та нараас биш харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр биш ажээ. Аврал бол бидний үйлсээр ирдэггүй. Иймээс хэн ч өөрөөрөө сайрхахгүй болно.(Ефес 2:8-9)

Бурханы үг 2

Бурханы үгэнд итгэж, аврагд. Есүс тэдэнд: Түүний илгээсэн нэгэнд итгэх нь Бурханы та нараас хүсэж буй ажил юм. (Иохан 6:29) Үнэнээр үнэнээр та нарт хэлье. Миний үгийг сонсоод, Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд гэмийнхээ төлөө яллагдахгүй. Харин үхлээс өнгөрч амь руу шилжив. (Иохан 5:24) Хүүтэй хүнд амь бий.Бурханы хүү байхгүй хүнд амь байхгүй. Та нар мөнх амьтай гэдгээ мэдээсэй гэсэндээ би Бурханы хүүгийн нэрд итгэдэг та нарт үүнийг бичлээ. (1 Иохан 5:12-13) Хүмүүсийн өмнө Есүсийг хүлээн зөвшөөр. Хэн надаас болон Миний үгсээс ичнэ, Бурханы хүү өөрийн суу алдараар ирэхдээ түүнээс мөн ичнэ. (Лук 9:26) Хэрэв та Есүсийг Эзэн хэмээн амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан түүнийг үхэгсэдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрнэ.(Ром 10:9-10) Авралын итгэл нь сайн үйлстэй байдаг. Ах дүүс минь, хэрэв хүн “Надад итгэл бий” гэж хэлчихээд үйлсгүй бол энэ нь ямар ашигтай вэ? (Иаков 2:14) Бурханы таалдаг зүйлсийг үйлдүүлэхийн тулд тэр та нарын дотор ажилладаг. (Филиппой 2:13) Тиймээ, бидний хүн бүр Бурханы өмнө тайлагнах болно. (Ром 14:12) Хэрэв чи Эзэнд үйлчлэхээс татгалзвал хэнд үйлчлэхээ өнөөдөр сонго. Би болон манай гэрийнхэн Эзэнд үйлчилнэ.(Иошуа 24:15)

Бурханы Авралын Энгийн төлөвлөгөө 1.

Таны амьдралын хамгийн чухал асуулт: Та үхээд Мөнхийн улсад очих уу? Мөнхийн улсад очихын тулд “Та дахин төрөх хэрэгтэй” гэж Бурхан хэлдэг.(Иохан 3:7) Бурхан, бидний хэрхэн дахин төрөх вэ? гэдгийг Библид хэлсэн. Эхлээд гэмээ хүлээн зөвшөөр. Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй.(Ром 3:23) Учир нь чи гэм нүгэлтэй тул үхэх ялтай. Нүглийн хөлс бол үхэл.(Ром 6:23) Энэ нь Бурханаас мөнхөд тусгаарлагдаж Тамд унана гэсэн үг. Шүүлт ирсний дараа үхэх нь хүн нэг бүрт тогтоогдсон.(Еврей 9:27) Гэвч Бурхан таныг хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Есүс чиний гэмийг үүрч чиний төлөө үхсэн. Гэвч биднийг гэмтнүүд байхад л Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан хайраа харуулсан.(Ром 5:8) Бурхан бидний гэмийг Есүс дээр үүрүүлж хэрхэн бидний төлөө үхүүлсэнийг бид ойлгож чадахгүй. “Бурхан, хүн бүхэн хаа сайгүй гэмшиж Түүнрүү эргэхийг тунхаглаж байна.”(Үйлс 17:30) Гэмших гэдэг нь гэмээсээ эргэж Бурханд улайж Есүс бидний төлөө загалмай дээр юу хийснийг хүлээн зөвшөөрөхийг хэлдэг. “Бид аврагдахын тулд юу хийх хэрэгтэй вэ “ гэдэг асуулт гарна. (Үйлс 16:30) Хариулт нь Есүс чиний гэмийг үүрч, загалмай дээр чиний төлөө үхэж, Бурхан түүнийг дахин амилуулсан гэдэгт Итгэх юм. Түүний дахин амилалт нь бид Есүсийг Аврагч хэмээн хүлээн авснаар мөнхийн амийг авна гэдгийг хүчтэйгээр харуулж байна. “Харин өөрийг нь хүлээн авсан болгонд, өөрийнх нь нэрэнд итгэдэг хүмүүст Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв”(Иохан 1:12)

Бурханы Авралын Энгийн төлөвлөгөө 2

“Эзэний нэрээр дуудах хэн ч аврагдах болно” (Ром 10:13) Итгэ, та аврагдах болно. Сүм ч, сайн үйлс ч чамайг аврахгүй. Бурхан л авардаг гэдгийг санагтун. Бурханы авралын энгийн төлөвлөгөө бол: Чи гэмшиж Есүс чиний төлөө нас барсан гэдэгт итгэхгүй бол мөнхийн зовлонд унана. Хэрэв чи Түүнийг цовдлогдсон, оршуулагдсан, дахин амилагдсан Аврагч гэдэгт итгэвэл Түүнээс уучлалыг авч итгэлээрээ бэлэг болгон мөнхийн амийг авах болно. Хэрэв Түүний төлөвлөгөө тодорхой биш байвал, үүнийг ойлгох хүртлээ цааш тавилгүйгээр дахин дахин уншаарай. Таны амь бүх дэлхийгээс ч илүү үнэ цэнэтэй. “Учир нь хүн бүх дэлхийг өвлөн авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ”. (Марк 8:36) Чи аврагдсан эсэхээ шалга. Хэрэв чи амиа алдвал, чи мөнхийн улсыг болон бүгдийг алдана. Хувирч байдаг зүрх сэтгэлдээ бүү найд. Харин хэзээ ч өөрчлөгддөггүй Бурханы амлалт дээр зогс. Чи аврагдсаны дараа, сүнснийхээ өсөлтийн төлөө хийх гурван зүйл бий. Эхлээд залбирал буюу Бурхантай ярих . Дараа нь Библиэ унш ингэснээр Бурхан чамтай ярих болно. Эцэст нь итгэлийхээ тухай бусадтай хуваалц. Ингэж чи Бурханы төлөө ярина. “Иймээс бидний Эзэний гэрчлэлээс бүү ич. (2 Тимот 1:8) “Харин намайг хүмүүсийн өмнө үгүйсгэсэн хэнийг ч болов Би тэнгэр дэхь Эцэгийнхээ өмнө үгүйсгэнэ” (Матай 10:32) Чи Есүс Христэд **дуулгавартай** байн нийтийн өмнө өөрийн Авралын гэрчлэл болгон баптисм хүрт. Мөн Библид итгэдэг сүмд нэгдээрэй.